

“СҮНЗИЙН ДАЙТАХУЙН УХААН” БА ОРЧИН ҮЕ

Ч.Таамаа – МУИС, ГХСС-ийн Хятад судлалын тэнхмийн профессор

Г.Наранцэцэг- Хүүхэд, гэр бүлийг дэмжих Тайваны сангийн ажилтан, Хятад судлалын магистр


Түлхүүр үг: Улс төр, тэнгэрийн утга, газрын байц, жанжин сайд, эш цааз

“Сүнзийн дайтахуйн ухаан” зохиол нь эртний хятадын сонгодог зохиол юм. Энэ зохиолын олон улсын нэр нь “The Art of War” (Хятадаар 孫子兵法; дуудлага нь: *Sūn Zǐ Bīng Fǎ*) болно. Энэ зохиолыг Сүнз нь Хавар Намар улсын үед бичсэн гэж үздэг байна. Түүний жинхэнэ нэр нь Сүн Ү бөгөөд хүндэтгэсэн буюу бичгийн нэр нь Сүнз /Sun Tzu/ юм. Тэрээр Сүнз хэмээх нэрээрээ дэлхий дахинд алдаршжээ. Сүнз /孫子; дуудлага нь *Sūn Zǐ*/ нь эртний Хятадын агуу их сэтгэгч, цэргийн генерал байсан. Сүнз нь энэхүү зохиолоороо Хятадын болон дэлхийн соёлд үнэтэй хувь нэмэр оруулсан хүн юм.

Сүнзийн үзэл их өргөн агуулгатай бөгөөд түүний философи, улс төр, ёс зүй, удирдахуйн ухааны үзлүүд бие биенийхээ үндэс болдог харилцан холбоотой юм. Тэрээр гүн ухааны үзлийн хувьд Күнзийн үзлийг баримтлагч боловч тэрхүү үзлийг зарим талаар шинэчилсэн байна. Тухайлбал, Күнзийн хувьд консерватив үзэлтэй байсан бол Сүнзийн гүн ухааны гол зарчим нь өөрчлөлтийн зарчим байгаа болно.

Энэхүү алдартай зохиолыг анх 2005 онд доктор М. Чимэдцэеэ Монгол хэлнээ орчуулсан ба манай дэлхий дээрх цэрэг дайны хамгийн эртний зохиол бөгөөд олон үеийн хүмүүсийн цэрэг дайны сэтгэхүй болон бизнес төлөвлөгөө зэрэгт ихээхэн нөлөө үзүүлсэн бүтээл юм. Түүхийн ном зохиолд тэмдэглэснээр, 1972 оны IV сард Шаньдун мужийн Линь И Гацааны Иньчяо уулнаас Баруун Хань улсын үеийн нэгэн булшнаас хулсны цуудсан дээр бичсэн “Сүнзийн дайтахуйн ухаан” номын эх бичвэр олдсон нь одоогоор хамгийн эртний эх бичвэрт тооцогдож байгаа юм.

Хулсан дээр бичсэн олдвор



Нангиад судлаач Я.Ганбаатар “Нангиадын сонгодог утга соёлын товчоон” бүтээлдээ тэмдэглэснээр: “Хүннүгийн шаньюй нар, ван ноёд нангиагийн сонгодог бүтээлийг багаасаа сурч судалж байсан тухай эртний түүхийн сурвалжид баттай

мэдээ занги тэмдэглэн үлдээснээс үзэхүл тэдгээрийн дотор “Сүнз бинфа” хэмээх байлдах урлагийн тухай эл туурвил багтаж байсан ажээ.”¹ гэжээ. Хүннүгээс хожуу үеийн Нирун улс, Хитан гүрний үед нангиадын зохиол бүтээлээс орчуулан хөрвүүлэх үйл уламжлал идэвхитэй дэлгэрсэн түүхтэй.

“Сүнзийн дайтахуйн ухаан” зохиолыг цэрэг дайны удирдлагадаа ашиглан ялалт байгуулж байсан дэлхийн олон орны удирдагчид байдаг байна. 1905 онд Орос Японы дайны үед, Японы цэргийн жанжин энэ зохиолыг ашиглан Оросын армийг ялж байжээ. Мөн Францын алдарт жанжин Наполеон, Германы Вильгем хаан, Оросын нэрт эрдэмтэн Е.А. Лавин зэрэг олон алдарт, удирдагч хүмүүс уг зохиолыг сонирхон судлаж, амжилт олж байжээ. Мөн Хятадын удирдагч Мао Зедун энэ зохиолыг өөрийн удирдахуйн ухаан болон дайны стратегидаа ашигладаг байжээ.

¹ Я.Ганбаатар. Нангиадын утга соёлын товчоон. УБ., 2006. 96 дахь тал

“Сүнзийн дайтахуйн ухаан” зохиол нь орос, япон, солонгос, франц, англи, герман, итали, грек зэрэг дэлхийн 29 хэлээр орчуулагдан хэвлэгдсэн дэлхийн хэмжээний сонгодог бүтээл юм. 1996 онд АНУ-ын Харвардын Их Сургуулийн эрдэмтэд дэлхийн 4000 жилийн түүхэнд тодорсон 10 алдарт бүтээлийн нэгээр шалгаруулсан нь эл судрын үнэ цэнийг тодорхой харуулж буй хэрэг юм.

Энэхүү зохиол дахь дайтахуйн ухааны янз бүрийн арга, томъёолол нь түүхийн олон үед томоохон удирдагчид амьдрал үйл ажиллагаандаа хэрэглэж, их амжилтад хүрсэн жишээ олон байна. Мөн орчин үеийн шилдэг бизнесменүүдийн амжилтын үндэс болж, тэдний ширээний ном болон хэрэглэгдэж байгаа юм.

Энэ бүтээлийн үндсэн үзэл санаа бол өөрийгөө болон өрсөлдөгчөө сайн судалж танин мэдэх, түүний үндсэн дээр үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулах арга ухаан юм. Түүний үзлээр, “өөрийгөө мэдээд өрсөлдөгчөө мэдэхгүй бол өрсөлдөөнд ялж ч болно, ялагдаж ч болно. Өөрийгөө ч мэдэхгүй, өрсөлдөгчөө ч мэдэхгүй бол хэзээ ч амжилтад хүрэхгүй”. Энэ зохиол нь зөвхөн цэрэг дайны асуудал биш, бас улс төр, бизнес, боловсролын зэрэг нийгмийн бүхий л салбарт ажиллаж буй хүмүүст мэдвэл зохих зүйлийг бичсэн бүтээл юм. Ялангуяа өнөөгийн өрсөлдөөний нийгэмд аль ч салбарын хүмүүсийн судалж, үйл ажиллагаандаа анхаарах ёстой зүйл олон байгаа болно.

“Сүнзийн дайтахуйн ухаан” зохиолын судалгаа Хятадад маш өргөн дэлгэр бөгөөд судалгаа, ном зохиол, кино жүжиг болон холбогдох хурал семинар маш их хэмжээгээр болдог. www.sunwuzi.com.cn нь “Сүнзийн дайтахуйн ухаан” зохиолын Хятад дахь албан ёсны сайт бөгөөд энэ цахим хуудсанд энэ зохиолтой холбоо бүхий сүүлийн үеийн мэдээлэл, судалгаа шинжилгээ, хурал семинарын зэрэг олон тооны мэдээлэл байдаг.

Хятад судлаачдаас Пү Ин Хуа¹ гэдэг сурган хүмүүжүүлэгч, Сүнзийн дайтахуйн ухаан болон зах зээлийн өрсөлдөөний судлаач мэргэжилтэн бөгөөд энэ талын судалгааны Хятад дахь томоохон төлөөлөгчдийн нэг юм. Тэрээр “Сүнзийн дайтахуйн” ухаан зохиолыг философи, сэтгэл судлал, нийгэм, урлаг зэрэг маш олон салбаруудад өргөн хэмжээнд судалгаа хийж түүгээрээ дотооддоо болон олон улсад зохиогддог хурал семинарт урилгаар илтгэл тавьдаг байна. Түүний бичсэн “Орчин цагийн хэл дээрх Сүнзийн дайтахуйн ухаан” ном нь “Сүнзийн дайтахуйн ухаан” судлалд нөлөө үзүүлсэн том бүтээл болжээ.

Мөн түүнчлэн “Сүнзийн дайтахуйн ухаан” зохиолын олон улсын судлалын нийгэмлэг ба солилцооны төвийн удирдах зөвлөлийн нийгэмлэг, Сүжөү хотын “Сүнзийн дайтахуйн ухаан” зохиолын олон улсын солилцооны төв болон Сүжөү хотын Сүнз судлалын нийгэмлэг зэрэг маш олон судалгааны төвүүд байна.

Түүнчлэн “Сүнзийн дайтахуйн ухаан” зохиолын үзэл санаа бизнестэй хэрхэн холбогдох талаар барууны орнууд болон Америкт өргөн хүрээтэй судлагдсан байна. “Сүнзийн дайтахуйн ухаан” зохиолыг орчин үеийн бизнест хэрхэн ашиглах талаар бизнес эрхлэгчдэд зориулсан олон арван судалгаа, ном зохиол, интернетийн сайт байдаг ба дэлхийн өндөр хөгжилтэй олон улс орны их дээд сургуулиудад уг зохиолыг заавал судлах хичээл болгосон байдаг.

Ийнхүү барууны орнуудад болон Хятадад “Сүнзийн дайтахуйн ухаан” зохиолыг орчин үеийн бизнестэй холбон судалж, түүнийхээ дагуу сургалт, семинар хийж, мөн албан байгууллага, компаниудад гэрээгээр, болон урилгаар, лекц уншдаг судлаачид, олон байна. “Сүнзийн дайтахуйн ухаан” зохиолыг орчин үеийн бизнест ашиглан хэрхэн амжилт олох талаар онлайн сургалт хүртэл байдаг ба эрдэмтэд болон бизнесменүүд байнга хурал зохион байгуулж санал бодлоо хуваалцдаг байна.

¹ www.当当.Com.cn

Тухайлбал, Америкийн судлаач Гари Гаглиарди нь “Сүнзийн дайтахуйн ухаан” зохиолыг маш олон салбарт өргөн хүрээтэй судлаж, их ном бүтээл бичсэн энэ талын судалгааны томоохон төлөөлөх хүн гэж хэлж болох юм. Тэрээр “Сүнзийн дайтахуйн ухаан” зохиолыг бизнестэй холбон 30 гаруй ном зохиол туурвисан бөгөөд амжилттай бизнес эрхлэгч, олон улсын стратегийн зааварлагч, энэ талын судалгааны зохиолчийн зэрэг олон арван шагналтай ажээ. Түүнчлэн тэрээр одоо үйл ажиллагаагаа явуулж буй 500-аад компанид бизнесийн зөвлөх хийж байжээ. Одоогоор олон тооны пүүс компани болон их дээд сургуулиудтай хамтран ажилладаг бөгөөд урилгаар хурал, семинар хийж бизнес стратегийн хичээл явуулдаг байна. Мөн Америкийн судлаач Марк. Р. Макнэйли¹ нь зохиолч, илтгэгч, бизнесийн зөвлөгч бөгөөд “Сүнз ба бизнесийн урлаг: Менежер эзэмшүүлэх зургаан зарчим” номонд Сүнзийн стратегийн зарчмуудаар орчин үеийн бизнест хэрхэн амжилт олох талаар бичсэн байдаг. Энэ номыг GE, Microsoft, AT&T, BMW, Southwest Airlines, FedEx болон бусад байгууллагууд ширээний ном болгон бизнестээ ашигладаг байна.

Английн судлаач Осама Эл-Кади “Сүнзийн дайтахуйн ухаан” зохиолын үзэл санааг орчин үеийн бизнестэй холбон дэлхийн олон улс оронд урилгаар очиж, семинарт хийж лекц уншдаг бөгөөд fujitsu siemens, HP, Hilton, Motorola, UBS investment bank, rolls Royce, BMW зэрэг дэлхийн томоохон байгууллага, компаниуд байнга хамтран ажиллаж, түүний удирддаг семинарт их анхаарал хандуулдаг ажээ. Нэгэн жишээг сонирхуулбал: C and I компанийн менежер Кевин Моррис хэлэхдээ: Би өөрийн хөгжиж буй компанийн менежментдээ энэхүү номыг байнга ашигладаг. Би энэ номын тавдугаар бүлэгт үндэслэл сард нэг удаа төлөвлөгөөгөө хэрэгжүүлдэг гэжээ.

“Сүнзийн Дайтахуйн ухаан” зохиол дахь бизнесийн удирдахуйн арга ухаанг асуудлын талаар авч үзсэн болно. Аливаа бизнесийн амжилт нь юуны өмнө бизнесийн орчны шинжилгээний асуудлаас ихээхэн хамаардаг. Энэ асуудлыг Сүнзийн дайтахуйн ухаантай холбон тайлбарлая. Энэ талаар “Арга ухаанаар эхлэхүй” хэмээх эхний бүлэг Сүнз өгүүлэхдээ: “Өөрийгөө хийгээд өстөн дайсныг таван талаас нь тандан харьцуулж ялахуй, ялагдахуйн хэргийг шинжвээс зохилтой”² гэжээ. Энд дурьдсан таван талаа тандан судлан шинжлэх зүйл бол: улс төр, тэнгэрийн утга, газрын байц, жанжин сайд, эцэс цааз хэмээх ойлголтууд юм. Эдгээр ойлголт нь орчны шинжилгээ хийхэд баримтлах гол зарчмууд юм. Одоо Сүнзийн зохиол дахь эдгээр ойлголтыг эдүгээчлэн тайлбарлая. Үүнд:

- Нэгд, Юуны өмнө “улс төр” гэдэг ойлголтын утга нь бизнес эрхлэх гэж байгаа бол нийгмийн эдийн засаг ба эрх зүйн орчин, бусад өрсөлдөгчөө судлах болон яма хүмүүстэй хамтран ажиллах сонголтоо зөв хийх хэрэгтэй болохыг илэрхийлдэг юм.

- Хоёрт, “Тэнгэрийн утга” гэдэг ойлголтын гол утга нь зах зээл дээр эрэлт яма байгааг судлах, бизнесийн үйл ажиллагааны чиглэл, цар хүрээгээ тодорхойлох явдал юм.

- Гуравт, “Газрын байц” хэмээх ойлголтын утга бол аливаа бизнест ашигта байршил олох нь чухал болохыг онцолдог байна.

- Дөрөвт, “Жанжин сайд” гэдэг ойлголтын утга нь бизнес эрхлэгч хүн өөрөө алсыг хараатай, хариуцлагатай, сахилга баттай, эрсдлийг хүлээх чадвартай, удирдахуйн аргыг ухааныг эзэмшсэн байх шаардлага юм.

- Тавд, “Эцэс цааз” гэдэг ойлголтын утга нь бизнестээ ямар техник технолог ашиглах, хэнээр юу хийлгэх буюу ажилчдын ажил үүргийн хуваарь тодорхой бай

¹ Mark R. McNeilly. Sun Tzu and the Art of Business: Six Strategic Principles for Managers. New York. Oxford., 1996

² 孙子兵法 УБ., 2005. 65 дахь тал

бизнесийн ёс зүйн дүрэмтэй байх, бизнесээ хуулийн хүрээнд хийх, бизнесийн урлагт суралцсан байх зэрэг болно.

Дайтахуйн буюу амьдрах арга ухааны талаар товч тодорхой өгүүлсэн энэ зохиолын талаар хятад судлаач, доктор М.Чимэдцэеэ хэлэхдээ: “нэг үгнээс нь мянган утга сацран гэрэлтсэн” сонгодог бүтээл хэмээн үнэлжээ. Амьдрал бол их ээдрээтэй зүйл бөгөөд бид амжилтын төлөө явахдаа алдах нь ч их байгаа. Тэгвэл тэр алдааг багасгахад энэхүү мэргэн сургаалаас суралцах нь чухал гэж үзэж байна.

Дайтахуйн ухааны буюу аливаа үйл хэрэгт амжилтанд хүрэх үндсэн зарчмуудыг Сүнз тодорхойлохдоо:

- “даруй үтэр ялахуй”¹ нь аливаа ажил хэрэг сунжрах тусмаа илүү их цаг болон хөдөлмөр, хөрөнгө мөнгө шаарддаг тул шуурхай ажиллаж байхыг сануулсан хэрэг юм.

- “өөрийн бие хийгээд өстөн дайснаа мэдэж байх” нь өөрийн болон өрсөлдөгчийнхөө эерэг бас сөрөг талыг сайтар мэдэж, улмаар хэрхэн ажиллах арга ухаанаа тодорхойлох гэсэн зарчим юм.

- “тагнуулын ажиллагаа явуулах” нь өрсөлдөгчөө сайн судлах хэрэгтэй гэсэн үг. Энэ талаар: “Аливаа дайныг эхлэхээс өмнө заавал тагнуулын ажиллагааг явуулж, өрсөлдөгчийн талаарх бүхий л мэдээ баримт болон тухайн дайны ажиллагаа явагдах газар нутгийн талаар хангалттай мэдэж авсан тохиолдолд л дайныг эхлэх хэрэгтэй”² гэж Сүнз өгүүлжээ.

- “дайсныхаа сул тал руу довтлох”³ энэ нь өнөө үед бол өрсөлдөгчийн сул дутагдалтай талыг мэдсэнээр түүнийг ялах боломжтой гэсэн үг юм.

- “дайныг эхлүүлэхээс өмнө бэлтгэлээ сайн хангах”, энэ бол аливаа ажил хэргийн үр дүн бэлтгэлээс шууд хамааралтайг анхааруулсан хэрэг юм.

- “тулааны үед маш хурдтай шуурга шиг довтлон орох” гэдэг нь аливаа ажил хэргийг удаашруулахгүй, шуурхай гавшгай байх нь амжилтын нэг үндэс болохыг тодорхойлсон явдал мөн. Өөрөөр хэлбэл, маргааш дараа гэж хойш тавихгүй, хурдан чанартай сайн хийх хэрэгтэй гэсэн үг юм.

- “тулаан маш хурдан, оновчтой байхаар сайтар төлөвлөгдсөн байх”⁴ нь ажлын төлөвлөгөө буюу зохион байгуулалт оновчтой сайн байх гэсэн үг бөгөөд сайн төлөвлөгөө бол нийт ажлын тавин хувьтай тэнцэнэ гэж ойлгож болно.

- “дайсны хүчийг сайн тооцох”, дайснаа дутуу үнэлж болохгүй бөгөөд “Ухаалаг жанжин нь өөрөөс хэт хүчтэй дайсантай тулахаас аль болох зайлсхийдэг бөгөөд дайсан өөрөөс хэд дахин их бол зугтана, хоёр дахин их бол ухраад салгаж тулна, адил бол ухаалаг тулна, цөөн бол довтолно, хэд дахин цөөн бол бүслэнэ”⁵ гэх мэтчилэн дайтах урлагийн олон зарчмуудыг тодорхойлсон байна. Эдгээр зарчмууд нь өнөөгийн өрсөлдөөний нийгэмд өрсөлдөөнд хэрхэн ялж, амжилтад хүрэх арга ухаан болон өргөн хэрэглэгдэж байна.

Түүнчлэн бизнес хийх гэж буй хүн эхлээд бизнесийн орчны шинжилгээг олон талаас нягтлан хийх талаар Сүнз өгүүлэхдээ: “Аль улсын эзэн хааны бодлого илүү мэргэн буй? Аль этгээдийн жанжин сайд чадвар төгс буй? Тэнгэрийн утга, газрын байц аль этгээдэд тустай буй? Аль этгээдийн зарлиг эш заавал биелэх нигууртай буй? Аль этгээдийн цэрэг илүү хүчирхэг буй? Аль этгээд цэргийг илүү сургасан буй? Аль этгээд

¹ Мөн тэнд. 26 дахь тал

² Сүнз. Дайтахуйн ухаан. Орч. М.Чимэдцэеэ. УБ., 2005. 61 дэх тал

³ Мөн тэнд. 38 дахь тал

⁴ Мөн тэнд. 25 дахь тал

⁵ Мөн тэнд. 29 дэх тал

Эндээс үзвэл бизнес төлөвлөгөө зохиохын тулд бизнес орчны шинжилгээ, дүгнэлт хийх асуудалд онцгой анхаарал тавих ёстой. Бизнесийн гадаад, дотоод орчны шинжилгээ, дүгнэлт хийх явдал бизнес төлөвлөгөө зохиох анхдагч бөгөөд чухал ажил юм. Бизнес орчны шинжилгээгээр тухайн байгууллагын давуу ба сул тал, албан хаагчдын болон удирдлагын удирдан зохион байгуулах чадвар, түүний хяналт болон бодлогын үр өгөөж, мөн байгууллагын санхүүгийн чадвар, тухайн зах зээлд төлөвлөж буй бараа бүтээгдэхүүний борлуулалт, өрсөлдөгч компанийн үйл ажиллагаа, баримтлаж буй бодлого зэрэг маш олон шат дараатай шинжилгээг сайтар хийсний үндсэн дээр төлөвлөж буй бизнес амжилт олох эсэх нь шийдэгдэнэ. Сүнзийн үзлээр, бизнесийн удирдахуйн ухаанд юуны өмнө бизнесийн орчны шинжилгээг сайн хийх нь чухал юм.

Мөн энэ өгүүлэлд бизнесийн удирдахуйн ухаанд бизнес төлөвлөлтийн асуудал чухал болохыг Сүнзийн үзэлтэй холбон тайлбарласан болно. Аливаа ажлыг төлөвлөхгүй хийнэ гэдэг нь асар их хөрөнгө мөнгө шаардаж, араасаа ихээхэн эрсдэл дагуулдаг болохыг Сүнз онцлон анхааруулсан байдаг. Ийнхүү хэн асуудлыг сайн бодож, тооцож, төлөвлөж урьдчилан үл үндэстэй боловсруулж чадна, тэр төдий чинээ өндөр амжилтанд хүрнэ гэдгийг Сүнз чухалчилсан байна.

Түүнчлэн сайн удирдагч хүний нөөцийг сайн бүрдүүлж, тэдгээр ажилчдаа өөртөө болон компанидаа ашигтайгаар хэрхэн ажиллуулах арга ухааныг зааж өгсөн нь өнөөгийн бидэнд амжилтад хүрэхэд ач холбогдолтой юм. Ажилтныхаа чадварыг нээн илрүүлж, биеийн болон оюун ухааны хүч чадлыг бүтээлч үйлсэд чиглүүлж чадсан удирдагч нь өрсөлдөөний нөхцөлд ялан дийлж, ашиг орлогоо нэмэгдүүлнэ. Компанийхаа ажилчдын сайшаан урамшуулж, идэвхжүүлэн, чадварыг үнэлж, мэдлэг боловсролыг нэмэгдүүлвэл ажилчид ажиллах урам зоригоор дүүрэн, идэвхтэй ажиллах хэдий ч хэрэв шагнал урамшуулал, хангамж хэрээс хэтэрвэл ажилчид биеэ тоон, ажлын бүтээмж муудах аюултай тул аливаа зүйлийг хэмжээнд нь барьж байх чухал гэсэн санааг Сүнз анхааруулсан нь зүйтэй юм. Удирдагч нь идэвхтэй ажиллаж, амжилт гаргасан чадварлаг ажилчнаа шагнаж урамшуулах зэрэгээр тогтоон барьж, бусад ажилчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд анхаарах нь амжилтын нэг үндэс болно.

Өнөөгийн бизнесийн амжилт нь түүний удирдлага, зохион байгуулалтаас ихээхэн хамаарна. Энэ талаар Сүнз олон чухал санааг боловсруулжээ. Тэрээр хэлэхдээ: “Эзэн хаан их цэргийн явдалд хор болохуй нь гурав буй: Их цэрэг урагш давшваас үл болохыг эс ухааран, мөнхүү урагш давшихыг мугуйдлан зарлигдахуй, их цэрэг арагш ухарваас үл болохыг эс ухааран, мөнхүү арагш ухрахыг адангалан зарлигдахуй, үүнийг их цэргийн үхэтгэн боомилохуй хэмээмэй, их цэргийн дотоод хэрэг явдлыг эс ухааран, хамаг цэргийн засахуйд хавирганаас нь оролцвоос жанжин сайд хийгээд цэргүүд төөрөлдмүй, их цэргийн хэрэг явдалд эрх хэргэмийг эс ухааран, цэргийг засахуйд цуг оролцвоос жанжин сайд хийгээд цэргүүд эргэлзмүй”¹ хэмээн аливаа ажилд удирдлага, зохион байгуулалт чухал гэдгийг тэмдэглэжээ.

Тэгвэл өнөө үед байгууллагын удирдлага, зохион байгуулалтын бүтэц нь ерөнхийдөө албан хаагчдад хариуцах ёстой үүргийг нь тодорхойлон хөдөлмөрийн хуваарь хийх, тухайн байгууллагын удирдагчдын хяналтын хүрээ болон хэнд захирагдах шатлалыг тодорхойлох мөн менежерүүдийн боловсруулсан бодлого болон албан ёсны дүрэм журам тогтоох юм. Удирдлага ерөнхийдөө менежерээр дамжин үе шаттайгаар албан хаагчдын ажлыг хянах шаардлагатай.

¹ 孙子兵法 УБ., 2005. 68 дахь тал

тогтоох юм. Удирдлага ерөнхийдөө менежерээр дамжин үе шаттайгаар албан хаагчдын ажлыг хянах шаардлагатай.

Удирдагчийн чадварын асуудал нь бизнест их чухал байдаг ажээ. Сүнзийн үзлээр, “Жанжин сайд болвоос эзэн хааны их тэрэгний арал буюу, эрэлхэг жанжин, эзэн хаан хоёр тэрэг, арал лугаа адил тарж салшгүй бат аваас төр улс хүчирхэг болмуй, тэрэг арал хоёр цав сууваас төр улс сулармуй”. Энэ үзэл бол удирдлага болон менежерүүд хоорондын санаа бодол, компанидаа тавьж буй зорилт, боловсруулж буй бодлого зэрэг дээр санаа нэг байж, хамтран ажиллах шаардлагатайг хэлж байна. Хэрэв удирдлага болон менежер хоёрын санаа бодол зөрж, санал зөрөлдвөөс компанийн үйл ажиллагаа цаашид үргэлжлэн явагдах ямар ч нөхцөлгүй болно.

Бизнест сайн удирдагч нь компанийн үйл ажиллагаа амжилттай явж чадах эсэхийг шийддэг талаар Сүнз өгүүлэхдээ: “Цэрэглэн дайлахуйд шилдэг жанжин болвоос олон хүмүүний үхэхүй, сэхэхүйг заагч, улс гэрийн оршихуй, мөхөхүйг мэдэгч буюу”¹ гэжээ. Мөн түүнчлэн түүний үзлээр, “Цэрэглэн дайлахуйд чинхүү гарамгай хүмүүн болвоос дайснаа дагаар оруулахаас бус, дайран эс довтолж”². Энэ үзэл нь чадварлаг бизнесмэн өрсөлдөгч компанийн үйл ажиллагааг зогсоож, үгүй хийхийг эрмэлздэггүй болохыг хэлж буй хэрэг юм.

Хүний нөөцийн асуудал нь бизнесийн удирдлагын нэг чухал асуудал юм. Энэ тухай Сүнз хэлэхдээ: “Цэрэглэн дайлахуйд чадвартан болвоос их цэргийг хоёронтоо эс хураан дайчилмой, амуу будааг хэдэнтээ алсаас эс зөөвөрлөмүй, зэр зэвсгийг улс дотроо засан сэлбэж, амуу будааг алив дайснаасаа булаан авмой, тэгвээс их цэргийн хүнс будаа элбэг хүрэлцэх амой”³ гэсэн буй. Энэ бол компанийн дотоод нөөц бололцоог бүрэн дүүрэн ашиглах чадвартай хүмүүнийг ажиллуулах тухай үзэл болно. Анхныхаа тооцсон хөрөнгө оруулалтаар л хийх ёстой ажлуудаа хийж дуусгахаар төлөвлөж бодит байдал дээр хэрэгжүүлж чаддаг тийм ажилтан хэрэгтэй. Мөн үүн дээр өөрийн болон бусад албан хаагчидтай санал туршлагаа солилцож, харилцан суралцаж мөн бусад өрсөлдөгч компанийн мэргэжил нэгтнүүдийнхээ туршлага чадвараас суралцаж чаддаг, өөрөө өөрийгөө хөгжүүлэх чадвартай ажилтанг хэлж байна.

Орчин үеийн бизнест Сүнзийн дайтахуйн арга ухааны зарчмуудыг хэрхэн хэрэглэж болох талаар авч үзье. “Сүнзийн Дайтахуйн ухааныг” бизнесийн дараахь үндсэн зарчмуудтай холбон ойлгож болно. Үүнд: нэгд, төөрөлдүүлэх аргыг хэрэглэх зарчим нь бизнесмен хүн өөрийн ашиг орлогоо дээд түвшинд хүргэхийн тулд хэрэглэх ёстой нэг үндсэн зарчим юм. Сүнзийн үзлээр, “Дайн бол хуурах, мэхлэх гэсэн үг”, “Цэрэглэн дайлахуй болвоос ов мэх хэрэглэхүйн арга ухаан бөлгөө. Тиймийн учир дийлж чадах аваас дийлж эс чадах мэт байгтун, мөхөөюү хэмээвээс мөхөөх санаа үгүй мэт байгтун, ойр байх аваас хол байх мэт, хол байх аваас ойр мэт байгтун, өстөн дайсан шунахай аваас өчүүхэн ашгаар татагтун, самуунтай аваас тохиолыг ашиглагтун, өстөн хүчтэй аваас өмнөөс нь шивээлэн хаагтун, хүчирхэг их ахул холдон зайлагтун, уур хилэн их ахул улам өдөөн хилэгнүүлэгтүн, өөр бусдыг доорд хэмээн басамжлах аваас, улам хөөргөн дэвэргэгтүн, халуун зуураа эе найртай ахул хатгаж бутаргагтун, шивээлж хороолоогүй үед довтлогтун, сэрэмж болгоомж үгүй үед хөдлөгтүн”⁴.

• • • Үүний жишээ нь, өрсөлдөгч танай байгууллагыг доройтуурай, туршлагагүй гэж үзэж байвал, өөрсдийн дотоодоо хүчирхэгжиж чадваржих замаар үйл ажиллагаагаа

¹ Мөн тэнд.

² Мөн тэнд.

³ Мөн тэнд. 67 дахь тал

⁴ 孙子兵法 УБ., 2005. 66 дахь тал

мэдээлэл дамжуул. Олон төрлийн мэдээлэл дунд тэд төөрч эхэлнэ. Харин шинээр явуулах гэж буй үйлдвэрлэл болон ямар нэг бодлогынхоо талаар эртнээс юу нь мэдэгдэхгүй нууцлаг мэдээлэл реклам цацах хэрэгтэй, нийтэд түгээх үедээ маш хурдацтайгаар, олон нийтэд хүртээл болж чадахаар байх хэрэгтэй бөгөөд ингэснээр нийгмийн анхаарлыг бүтээгдэхүүн дээрээ татаж чадна.

хоёрт, зах зээлд өөрийнхөө байр суурийг олж авах зарчим нь бизнес төлөвлөгөөгөө боловсруулаад, үр дүн нь эерэг гарвал даруй ажилдаа орох, мөн төлөвлөгөөний дагуу богино хугацаанд эмх цэгцтэй, хурдан шуурхай үйлдвэрлэл, үйл ажиллагаа явуулах шаардлагатай гэсэн үг. Өөртөө эрсдэл учруулалгүйгээр хэрхэн зах зээлд байр сууриа олж авах талаар Сүнз хэлэхдээ: “Цэрэглэн дайтахуйд, үтэр хурдан ялахыг хичээюү, сунжран удваас их цэрэг сульдаж, хурц зориг нь халирч мохмуй, хот балгадыг довтолвоос хамаг хүчийг бармуй, харь улсад их цэрэг удаан сууваас хамаг улсын эд хөмрөг хоргодож дутмой”¹ гэжээ.

Энэ бол бизнес төлөвлөгөөг сар, улирлаар гаргасан нь хамгийн оновчтой бөгөөд бизнес төлөвлөгөөгөө боловсруулаад үр дүн нь эерэг гарвал даруй ажилдаа орох шаардлагатай гэсэн үг. Энэ зарчмын өнөөгийн утга нь тухайн компани үйл ажиллагаа орлого олохгүй удах нь үргүй зардлыг нэмэгдүүлнэ. Ашиг орлого олохгүй удвал ажилчид менежерүүд урам зориг мохно. Эцэст нь компани зорьсон зорилгодоо хүрж чадалгүй дампуурах болно. Тиймээс төлөвлөсөн ажлыг цаг алдалгүйгээр түргэн гүйцэтгэж дуусгаж байх хэрэгтэй.

гуравт, өрсөлдөгчөө довтлох зарчим нь өрсөлдөгчийнхөө давуу талаас зайлсхийж, түүний сул талыг олж харж, өрсөлдөгч компаниудынхаа талаар мэдээлэл цуглуулж, тэд хэн байх, тэдний өрсөлдөх чадвар, арга хэлбэр, ямар үйлдвэрлэл үйлчилгээгээр онцлог болон юугаар бусдаас илүү чадварлаг болох, танай компаниас илүү хүчирхэг эсвэл сул байгаа эсэхийг сайтар танин мэдэж, түүнд зохицуулан үйл ажиллагаагаа явуулах нь амжилтад хүргэнэ гэсэн утгатай зарчим юм. Энэ талаар Сүнз өгүүлэхдээ: “Дайсныг магадлан шинжиж, дайтах арга ухааны нь давуу хийгээд сулыг мэдэгтүн, дайсныг өдөөн дуудаж, үйл хөдлөлийг нь учир шалтгааныг ологтун, дайсныг хуурмаглан туршиж, үхэхүй, сэхэхүй нь амин судлыг мэдэгтүн, дайсныг багахан дайлж, эмзэг сул, эрч чадлыг нь танигтун”. “Өөрийн бие хийгээд өстөн дайснаа мэдэж байваас хэдүй зуунтаа дайтавч, хэзээд эс ялагдмуй, өстөн дайснаа эс мэдэж, өөрийн биеийг мэдэх аваас ялахуй байвчиг ялагдахуй бас буй, өстөн дайснаа эс мэдэж, өөрийн биеийг ч эс мэдвээс дайтах бүрүйд ялагдмой”² гэжээ.

Өнөө үед бизнес хийхэд өөрийнхөө болон бусад өрсөлдөгч компаниудын давуу тал, сул тал, онцлогийг харьцуулан бизнес орчны шинжилгээг сайтар хийсэн байх шаардлагатай. Өрсөлдөгч компаниудынхаа талаар мэдээлэл цуглуулж, тэд хэн байх, тэдний өрсөлдөх чадвар, арга хэлбэр, ямар үйлдвэрлэл үйлчилгээгээр онцлог болон юугаар бусдаас илүү чадварлаг болох, танай компаниас илүү хүчирхэг эсвэл сул байгаа эсэхийг сайтар таних хэрэгтэй. Өрсөлдөгч компанийн талаар мэдээлэл бага байх тусам тэдэнтэй адил үйлдвэрлэл үйлчилгээ явуулахад аюултай бөгөөд эрсдэлтэй юм.

дөрөвт, төлөвлөсөн арга техникээ бүрэн ашиглах зарчим нь компани өөрийн бүх нөөц, бололцоог дээд зэргээр сайн зохион байгуулж ашиглах зарчим юм. Энэ зарчим нь бизнесмен хүн өөрийн ашиг орлогоо дээд түвшинд хүргэхийн тулд хэрэглэх ёстой нэг үндсэн зарчим юм. Үүний жишээ нь, өрсөлдөгч танай байгууллагыг дорой буурай.

¹ Мөн тэнд. 67 дахь тал

² 孙子兵法 УБ., 2005. 68 дахь тал

туршлагагүй гэж үзэж байвал, өөрсдийн дотоодоо хүчирхэгжиж чадваржих замаар үйл ажиллагаагаа цэгцэлж, ашиг орлогоо нэмэгдүүлэн, зах зээлээ өргөтгөж амжих хэрэгтэй.

тавд, шинэчлэл ба өөрчлөлтийн зарчим нь өрсөлдөгчийнхөө үйл ажиллагааг тагнан мэдээлэлтэй байж, түүний үндсэн дээр өөрчлөлт хийж, амжилтад хүрэх зарчим юм. Түүний үзлээр, тагнуул туршуулыг зарахуй ёсон тав буй. Үүнд: уугуул тагнуул, суугуул тагнуул, сөргүүл тагнуул, үхмэл тагнуул, амьд тагнуул эдгээр болно.

Ийнхүү бид өнөөгийн нийгэмд бусадтай өрсөлдөхдөө юуны түрүүнд аливаа асуудлыг бүх талаас нь нарийн тооцоолж, хэтийн зорилго болон түүнийг хэрэгжүүлж, хэрхэн амжилтанд хүрэх арга замыг “Сүнзийн Дайтахуйн ухаан” зохиолын үзэл санаатай холбон тайлбарласан болно.

Composed of 13 chapters, “Sun tsu The Art of War” has also been applied to business and managerial strategies, **political dispensation, educational management, social relations, psychology** etc. “Sun tsu The Art of war” will give you background, tips, techniques and skills on everything from meaning of strategy to business application: negotiation, sales, leadership, management and application in life leading to great and unimaginable success. **The five elements** or steps must be considered and analysed in any strategic planning process.

1. **“The Moral Law”** - what unifies or creates unity between the leader of the business, the people working in business, and the customers. It is not enough to create a mission stating that you will be the best company in one particular sector or another. A mission is much more serious and much more practical than that.
2. **“Heaven”** - is where the contest takes place. The ground provides the prize you seek to win. It defines the game you are playing, and each game with its own unique rules.
3. **“Earth”** These are all in the realm of Methods that your business needs to understand and get right from the outset.
4. **“The Commander”** - is the unique quality of character and leadership that you bring your situation. Command is the realm of decision-making and personality.
5. **“Method and discipline”** describes the skills that you master to work with other people. They are the realm of methods and techniques.

Five important principles of the art of war in business: Shaping the Enemy, Speed and Preparation, Avoid Strength, Attack Weakness, Deception and Foreknowledge, Changes and Employing Spies etc.

Ном зүй

- Сүнз. Дайтахуйн ухаан. Орч. М.Чимэдцэсэ. УБ., 2005
- Р.Дарьхүү. Г.Эрдэнэбаяр. Философийн түүх. УБ., 2006
- Фэн Ю Лань. Хятадын философийн товч түүх. УБ., 2003
- Н.Эрдэнэ-Өрнөх, Б.Дөлгөөн. Бизнес төлөвлөлт ба Сүнз. УБ., 2006
- Zhonghua mingzu jiechu renwu chuan. Beijing. 1984.
- Zhongguo zhexueshi. Beijing. 2003
- 孙子兵法与三十六计 鲁中杰 编著 黄河出版社 1996年
- 孙子兵法 现代翻用 上官觉人 解译 中国华侨出版社 2004年
- www.easy-strategy.com
- www.suntzu1.com
- www.sonshi.com
- www.garygagliardi.com
- www.sunwuzi.com.cn
- Mark R. McNeilly. Sun Tzu and the Art of Business: Six Strategic Principles for Managers. New York. Oxford., 1996
- Donald G. Krause. Ancient Knowledge for Today's Business Professional. New York., 2005.